

Холбоо барих:



Каранда Петр
Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үйлчилгээний хэлтсийн Партнер
PwC Чех
petr.kranda@pwc.com



Рагчаахүүгийн Мөнжаргал
Ахлах менежер
PwC Монгол
munkhjargal.ragchaakhuu@pwc.com



Чулуунбатын Номин-Эрдэнэ
Хуульч
PwC Монгол
nomin-erdene.chuluunbat@pwc.com

Дэлгэрэнгүй мэдээлэл:
<https://www.pwc.com/cz/en/služby/forenzni-služby/financial-crime.html>

Харилцагчийн эрсдэлийг үнэлэх (CRR) моделиг сайжруулах нь

Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн байгууллагууд төрөл бүрийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Үүний нэг нь өндөр эрсдэлтэй асуудлуудыг тодорхойлж, эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх явдал юм. Энэ хүрээнд CRR моделиг оновчтой боловсруулах нь эрсдэлийг илүү үр дүнтэй, хурдан шуурхай хянахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

CRR моделиг сайжруулах хэрэгцээ:



Хуулийн шаардлага ба эрсдэлийн хамрах хүрээ

Байгууллагууд өөрсдийн CRR моделоо оновчтой ажиллаж байгаа эсэх, одоогийн нөхцөл байдал, хүлээлтэд нийцэж байгаа эсэхийг шалгалгүйгээр олон жилийн турш ашигласан байдаг. Иймд МУТСТ хяналтын тогтолцоо, тэр дундаа CRR моделоо сайжруулахын тулд дотоодын хууль тогтоомж, олон улсын сайн туршлага (Европын Банкуудын Холбоо (ЕВА)-ны удирдамж)-д нийцэж байгаа эсэхийг шалгаж, шаардлагатай өөрчлөлтийг хийж байх шаардлагатай.

Харилцагчдын эрсдлийн ангилалын хангалтгүй байдал

Бидний ажигласнаар манай улс дахь санхүүгийн байгууллагуудын CRR модел харилцагчидаа хангалттай түвшинд ялган ангилдаггүй байдал түгээмэл. Тухайлбал “иргэн” харилцагчийн дийлэнх хувь нь “бага” эрсдэлтэй ангилалд орох нь нийтлэг. Энэхүү байдал нь “эрсдэлд суурилсан хяналт”-ыг үр дүнтэй хэрэгжихэд сөрөг нөлөө үзүүлдэг.

Тодорхой харилцагчдад төвлөрөх

CRR моделиг боловсруулахдаа практикт ихэвчлэн хуульд заасан цөөн тооны эрсдлийн шалгуур үзүүлэлт болон болон хэт хатуу буюу уян хатан биш үнэлгээний аргачлалд суурилах хандлагатай байдаг. Улмаар харилцагчийн улс төрийн оролцоо, газар зүйн байршил, бизнесийн үйл ажиллагаа гэх мэтээс шалтгаалан шууд бага/дунд/өндөр эрсдэлтэйн аль нэгт ангилагддаг. Эдгээр дээр нэмэгдэх бусад шалгуур нь байх боловч тийм ч өргөн хүрээнд биш. Гэтэл бусад чухал үзүүлэлтүүд болох харилцагчийн зан төлөвтэй холбоотой үзүүлэлтүүдийг CRR моделд оруулалгүй орхигдуулах хандлага байна.

Дараагийн хуудсан дээр нийтлэг ажиглагддаг ерөнхий асуудлуудыг харна уу.



Нийтлэг гардаг болон бусад алдаа дутагдлуудыг илрүүлж, залруулахад бид танд тусална.



“Иргэн” харилцагчийг “дунд түвшний эрдэлтэй”-д ангилах хувь өндөр: Үндсэн нөлөө үзүүлэгч хүчин зүйлүүдийг шинжилж, илүү нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай.



“Иргэн” харилцагчийн эрсдэлийн профайлд зөвхөн цөөн тооны эрсдэлийн үзүүлэлтүүд ашиглагддаг: Ашиглагдаагүй эсхүл дутуу ашиглагдсан өгөгдлүүдийн параметруудийг харилцагчийн өгөгдлийн статистик тархалтыг илэрхийлэхүйцээр тохируулах шаардлагатай.



Харилцагчийн зан төлөвтэй холбоотой эрсдэлийн үзүүлэлтүүд огт ашиглагддаггүй эсхүл хангалтгүй: (Шинэ) Харилцагчийн хэвийн зан төлөвийн өөрчлөлт/хазайлтын түвшинээс шалтгаалан харилцагчийн эрсдэлийг үнэлгээний үзүүлэлтийг тохируулж болно.



Тавигдаж буй шаардлага болон CRR моделин үл нийцэл: Гадаад болон дотоод шаардлагууд нь CRR моделин бизнес зорилгод зөв тусгалаа олсон эсэхийг шалган баталгаажуулах нь зүйтэй.



CRR моделин үнэлгээний шалгуурын хэт ерөнхий байдал нь тухайлсан харилцагчийн эрсдэлийг хангалттай харуулдаггүй: Илүү нарийвчилсан үнэлгээний хэмжээс, дэлгэрэнгүй ангиллын хүрээнд эрсдэлийг оновчтой үнэлэх шаардлагатай.



CRR моделиг ашиглах зорилго болон түүний бодит хэрэгжилтийн хоорондын үл нийцэл: Програмын тохиргоо, түүнд оруулсан шалгуур үзүүлэлтүүдийг шалгах, эсвэл тест хийж баталгаажуулах байдлаар аливаа алдаа эсвэл буруу үзүүлэлтүүдийг илрүүлэх боломжтой.



Тогтмол буюу өөрчлөгддөггүй эрсдэлийн үзүүлэлтүүдийн нөлөө хэт өндөр байх: Шалгуур үзүүлэлтийн дүрмийг харилцагчдын өгөгдлийн статистик тархалттай уялдуулан тохируулж, илүү нарийвчилсан ангилалтай болгох шаардлагатай.

Танай байгууллагын CRR модел зохих түвшинд ажиллаж буй та эсэхэд эргэлзэж байна уу?
Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбогдоорой.



Манай “Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх болон Аналитикийн чиглэлийн үйлчилгээ” нь CRR модел, гүйлгээний хяналт, хоригийн хяналт болон залилан илрүүлэх системийн үйл ажиллагаатай холбоотой дараах төрлийн үйлчилгээг үзүүлэх боломжтой:



Вендор буюу системийн ханган нийлүүлэгчийг сонгох



Системийн интеграци



Хөндлөнгийн үнэлгээ



Системийн сайжруулалт

www.pwc.com/mn

© 2026 Энэхүү мэдээллийг ПрайсвотэрхаусКүүпэрс Чех s.r.o болон Өмгөөллийн ПрайсвотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хуулийн зөвлөгөө биш юм. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэхүү мэдээлэлд дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага бөгөөд үйл ажиллагаа явуулахдаа энэхүү брэндийг ашиглана. Гишүүн фирмүүд хамтдаа PwC-г бүрдүүлдэг ба байгууллага бүр нь тусдаа хуулийн этгээд бөгөөд PwCIL эсвэл бусад гишүүн фирмийн алиных нь ч төлөөлөгч байдлаар ажилладаггүй. PwCIL нь үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлдэггүй. PwCIL нь гишүүн фирмүүдийн аливаа үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага хүлээхгүй бөгөөд тэдгээрийн мэргэжлийн шийдвэр гаргалтад нөлөөлөх, хянах эсвэл ямар нэгэн байдлаар тэднийг төлөөлөн үүрэг хүлээлгэх боломжгүй.

